






Бүлэг сэдэв:4 “ Хүний эрх ба хууль

Сэдэв: ХУУЛЬ ХҮНИЙ ЭРХИЙГ
ХЭРХЭН ХАМГААЛДАГ ВЭ?

Хамрах хүрээ: 9 анги

УЛААНБААТАР
2021

Нийгэм судлал
Багш:
З.Цэвэгмиджав



Өмнөх хичээлээрэй.
Хүний эрх, эрхийн
ангилал, хэрхэн эрхээ
мэдэж, хамгаалж
үүргээ биелүүлэх
тухай үзэж судалсан

Энэ хичээлээрээ: Эрх зүйн эх сурвалж болох хуулийн талаар судлах болно.



Эрх зүй нь хуулийг өөртөө агуулсан, түүнээс илүү өргөн утгатай ойлголт юм. Эрх зүйд нийтээр заавал биелүүлэх ёстой хуулиас гадна, түүнийг хэрэгжүүлэх байгууллага, хүмүүс, дагаж мөрдөх үйл ажиллагаа зохион байгуулалт зэрэг олон үйл явц хамаардаг.

Эрх зүйн ХЭМ ХЭМЖЭЭ ГЭДЭГ НЬ:

1

Эрх зүйн хэм хэмжээ нь хүн, нийгмийн олон талт харилцаанд оролцох үедээ юу хийж болох болохгүй тодорхойлж өгдөг.

2

Бүх нийтээр дагаж мөрдөхөөр төрөөс тогтоосон хэм хэмжээний тогтолцоог эрх зүй гэдэг.

3

Эрх зүйн гол эх сурвалж нь хууль байдаг.

4

Хууль нь тухайн улсад амьдарч буй хүмүүс, иргэдийн нийтлэг эрх ашгийг хангахын төлөө үйлчилдэг.



Эрх зүйн хэм хэмжээ хүчин чадлаар нь хоёр ангилж авч үздэг.

01


ХУУЛЬ

Хууль тогтоох байгууллага болох Улсын их хурлаас батлан гаргаж, нийтээр дагаж мөрдүүлэх хэм хэмжээ тогтоон, биелэлтийг нь төрийн албадлагын хүчээр хангаж байдаг бичмэл эрх зүйн хэм хэмжээг хууль гэнэ.

02

ХУУЛЬЧИЛСАН АКТ

Нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн харилцааг зохицуулахаар захиргааны байгууллага, албан тушаалтнаас бичгээр гаргасан захирамжилсан шийдвэрийг хуульчилсан акт гэнэ..



Эрх зүйн эх
сурвалж болох хуулийн талаар
судлах болно. Тэгвэл хууль гэж
юу вэ?



Хууль нь:

Нийгмийн харилцаанд оролцож буй
иргэдийн эрхийг хамгаалах, тэгш
боломж олгох, шудрага ёсыг тогтоох
гол зорилготой.

Хуульчилсан актад дараах бичиг баримтууд орно.

Хуульчилсан актууд болон тухайн актуудыг батлан гаргах субъектуудыг нэрлэе.



Тогтоол
Батлан гаргах
субъект

Улсын их хурал,
засгийн газар,
улсын дээд шүүх



Зарлиг
Батлан гаргах
субъект

Ерөнхийлөгч.



Тушаал
Батлан гаргах
субъект

Сайд, Засгийн
газрын
агентлагийн
дарга



Захирамж
Батлан гаргах
субъект

Аймаг,
нийслэлийн засаг
дарга

Шийдвэр
Батлан гаргах
субъект.

Үндсэн хуулийн цэц,
Аймаг, нийслэлийн ИТХ,
УИХ-аас томилогддог
байгууллагуудын дарга,
түүнтэй адилтгах бусад
албан тушаалтан

Хүмүүс авьяас билиг ур чадвар,
гадаад байдал дуртай зүйл зэрэг
хувийн шинжээрээ өөр өөр
байдаг. Гэхдээ хүн бүр хуулийн
өмнө адил тэгш эрхтэй юм.



Өөрөөр хэлбэл: Хүн бүр төрөлхөөсөө
адил тэгш эрхтэй тул хуулийн өмнө
эрх тэгш байна. Хүн бүр хуулиар
хамгаалуулах эрхтэй болохыг
Монгол Улсын Үндсэн хууль болон
бусад
хуульд баталгаажуулсан байдаг.

Ардчиллын үндсэн зарчим бол хуулиас дээр хэн ч байх ёсгүй. Энэ зарчим нь төрийн дээд албан тушаалтнаас эгэл жирийн иргэн хүртэл бүгдэд нь тэгш үйлчлэх учиртай гэсэн үг юм.

Монгол улсын үндсэн хуулийн 14 дүгээр зүйл




Монгол улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө рэх тэгш байна хэмээн заасан байдаг.

Дээрх ойлголтуудаас хамаарч ялгаварлан гадуурхаж үл болно.
ХҮН БҮР ЭРХ ЗҮЙН ЭТГЭЭД БАЙНА.

Хүн бүр хуулийн өмнө эрх тэгш байх зарчмыг

Дараах агуулгаар тайлбарладаг.

Хуулийн этгээд



Үүнд:

- Хүн бүр хууль ёсыг сахих
- Хууль бүх хүнд адил тэгш үйлчлэх
- Шудрага шүүхээр шүүлгэх
- Гэм буруутай нь тогтоогдвол хариуцлагаас үл хэлтрэх
- Ял зэм хариуцлага үйлдсэн хэрэгт нь тохирсон байх зэрэг болно.

Мөн хууль дүрэм нь хүний эрхийн хэм хэмжээ, зарчмуудад нийцсэн байх ёстой.

Эрх зүйн хэм хэмжээ нь нийгмийн амьдралын зохицуулалтаас урган гардаг тул уг харилцаанд оролцогчдод ойлгомжтой тодорхой байх ёстой.



Хууль эрх зүйн талаар тодорхой мэдлэг ойлголттой байх нь өөрийн эрх, эрх ашгийг хамгаалах, мөн бусдын эрхийг зөрчихгүй байхад туслана.

Хуулийн заалт нь тодорхой бус бүрхэг байвал дагаж хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, мөн оролцогчид янз бүрийн байдлаар ойлгож тайлбарлан маргаанд хүрч болзошгүй юм.



Аливаа хууль хүмүүсийн нийтлэг эрх ашигт нийцсэн, түүнийг хамгаалахын төлөө байх ёстой.

Хуулиа мэддэг хүн эрхээ хамгаална.

Хэн нэгэн албан тушаалтан, хүний эрхийг зөрчсөн, ялгаатай хандсан зэргээр хуульд харшилсан шийдвэр гаргасан бол тэрхүү шийдвэр нь хүчингүй болох ёстой.

Өөрөөр хэлбэл иргэдийн эрх ашгийг зөрчсөн хууль тогтоомж гаргасан тохиолдолд иргэд түүнийг өөрчлөх саналаа өөрсдийн сонгосон төлөөлөгчдөөрөө дамжуулан хууль тогтоогчдод хүргэх замаар хуулийг шинэчлэн өөрчлөх боломжтой юм.





Thank you